

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ  
ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД  
АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН  
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2023 оны 7 сарын 18-ны өдөр

Мандалговь хот

**Нэг: Хяналт- шинжилгээний зорилго**

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж гэрээний хэрэгжилтийн талаар аймгийн болон хэлтэс агентлагуудын удирдлагуудыг мэдээллээр хангахад хяналт-шинжилгээний зорилго оршино.

**Хоёр. Хяналт- шинжилгээний үндэслэл, арга зүй**

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхдээ агентлагуудаас ирсэн тайланд үндэслэн Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт – шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримталж хэрэгжилтийн явцын дүнг гаргасан.

**Гурав. Хяналт – шинжилгээ, үнэлгээний явц**

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн 2023 онд хэрэгжүүлэх гэрээний хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт– шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.7-г үндэслэн 6.3-т заасан аргачлалын дагуу явцын хяналт-шинжилгээ хийхэд эхний хагас жилийн байдлаар 91.9 хувийн хэрэгжилтийн явцтай байна.

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн 2023 онд хэрэгжүүлэх гэрээний хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний эхний хагас жилд Бодлогын баримт бичиг, хууль тогтоол шийдвэрийн хэрэгжилт байгууллагын үйл ажиллагааны биелэлтийг 2023 онд тайлагнах хугацааны дагуу 13 гэрээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, холбогдох яамдад хүргүүлсэн.

Гэрээний хэрэгжилтийн явцын үнэлгээг хүснэгтээр харуулбал:


№	Яам / сайд/-ын нэр	заалтын тоо	дундаж хувь	тайлан ирүүлсэн хугацаа	Хоцроосон хугацаа хоногоор	Хугацаа болоогүй болон удаашралтай байгаа заалтын тоо
1	ЗГХЭГ-ын дарга	37	90.1	6 сарын 23	3	5
2	БШУЯам	118	92.4	6 сарын 28		5
3	Эрчим хүчний яам	21	73.3	6 сарын 19		5

4	Барилга хот байгуулалтын яам	84	79.8	6 сарын 9		37
5	Эрүүл мэндийн яам	89	91.4	6 Сарын 7	2	3
6	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	102	57.2	6 сарын 8		52
7	БОАЖЯам	45	70.3	6 сарын 13	1	18
8	Хууль зүй дотоод хэргийн яам	38	93.9	6 сарын 6		3
9	Соёлын яам	68	94.2	6 сарын 29		5
10	Батлан хамгаалах яам	32	87.1	6 сарын 12		7
11	Гадаад харилцаа	11	100.0	6 сарын 28	5	-
12	Эдийн засаг, хөгжлийн сайд	24	90.8	6 сарын 7	1	1
13	Биеийн тамир спортын үндэсний хороо	9	81.9	6 сарын 19		2
Дүн		678	91.9			143

Гэрээний үүргийн хэрэгжилтийг сүүлийн 5 жилийн эхний хагас жилээр харуулбал:

д/д	Яам /сайд/-ын нэр	2019 он эхний хагас жил	2020 он эхний хагас жил	2021 он эхний хагас жил	2022 он эхний хагас жил	2023 он эхний хагас жил
1	Монгол улсын Шадар сайд	-	74.7	-	-	-
2	Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд	-	87.6	-	-	-
3	ЗГХЭГ-ын дарга	89.5	-	-	87.2	90.1
4	БШУЯам	89.2	64.8	89.4	82	92.4
5	Эрчим хүчний яам	60.6	68.3	69.1	82.1	73.3
6	Барилга хот байгуулалтын яам	68.2	76	76.6	88	79.8
7	Эрүүл мэндийн яам	77.9	91	86	61.5	91.4
8	Зам тээврийн хөгжлийн яам	-	-	-	-	-
9	ХХААХҮяам	67.1	83.3	-	-	-
10	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	56	83	76.6	67.5	57.2
11	БОАЖЯам	58.5	-	67.2	61.5	70.3
12	Сангийн яам	92	-	-	-	-
14	Хууль зүй дотоод хэргийн яам	81.6	82	72	85.5	93.9
15	ЭЗХСайд	-	-	-	90	90.8
16	Соёлын яам	-	-	71.1	91.2	94.2
17	Батлан хамгаалах яам	-	-	82	94.6	87.1
18	Гадаад харилцааны сайд	-	-	-	83.3	100
19	Биеийн тамир спортын үндэсний хороо					81.9
20	Дүн	69	80.1	76.6	81.2	91.9

Хэрэгжилтийн явцыг графикаар харьцуулан харуулбал: /5 жил/



■ 2019-6 сар    ◻ 2020-6 сар    ◻ 2021-6 сар    ◻ 2022-6 сар    ■ 2023-6 сар

## Дөрөв. Дүгнэлт

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт буюу 13 яамдын төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 91.9 хувьтай байна.

Эхний хагас жилд нийт 13 гэрээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 678 заалтаас 143 заалт хэрэгжилт удаашралтай болон хугацаа нь болоогүй заалтууд байна. Хугацаа болоогүй 51 заалт буюу 35.6 хувь, хэрэгжилт удаашралтай 92 буюу 64.3 хувийг тус тус эзэлж байна. Үүнээс харахад Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын гэрээний заалтуудаас 51 хувь, Барилга хот байгуулалтын сайдын гэрээний заалтуудаас 44 хувь Байгаль орчин аялал жуулчлалын сайдын гэрээний заалтуудаас 40 хувь нь хугацаа болоогүй болон хэрэгжилт удаашралтай заалтууд байна.

Харьцуулан хүснэгтээр харуулбал:

№	Яам / сайд/-ын нэр	заалтын тоо	Хугацаа болоогүй	удаашралтай байгаа заалтын тоо	Нийт хугацаа болоогүй болон удаашралтай заалтын тоо	Нийт заалтад эзлэх хувь
1	ЗГХЭГ-ын дарга	37	1	4	5	13.5
2	БШУСайд	118	1	4	5	4.2
3	Эрчим хүчний сайд	21	3	2	5	23.8
4	Барилга хот байгуулалтын сайд	84	19	18	37	44.0
5	Эрүүл мэндийн сайд	89	-	3	3	3.4
6	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд	102	12	40	52	51.0
7	БОАЖСайд	45	8	10	18	40.0
8	Хууль зүй дотоод хэргийн сайд	38	-	3	3	7.9
9	Соёлын сайд	68	3	2	5	7.4
10	Батлан хамгаалахын сайд	32	4	3	7	21.9
11	Гадаад харилцааны сайд	11	-	-	-	
12	Эдийн засаг, хөгжлийн сайд	24	-	1	1	4.2
13	Биеийн тамир спортын үндэсний хороо	9	-	2	2	22.2
<b>Дүн</b>		<b>678</b>	<b>51</b>	<b>92</b>	<b>143</b>	<b>21.1</b>

Удаашралтай байгаа заалтуудын жагсаалтыг файлаар хүргүүлэв.

### Тав. Зөвлөмж

#### Үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар өгөх зөвлөмж

#### Боловсрол шинжлэх ухааны сайд:

Цэцэрлэг сургуулийн хүнсний хангамжийг сургуулийн дэргэдэх туслах аж ахуйг хөгжүүлэх, тухайн орон нутгийн хүнсний үйлдвэрлэл, орон нутгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Политехник коллежийг түшиглэн хоолны бэлдэц бэлтгэн нийлүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах

### **Эрчим хүчний сайд:**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай" 144 дүгээр тогтоол, Эрчим хүчний сайдын 2020 оны 111 дүгээр тушаалаар баталсан төлөвлөгөөний дагуу аймгийн төсвийн байгууллагуудыг тоолууржуулах ажил байгууллагуудын хөрөнгийн асуудлаас болж тасраад байгаа тул төсөвтөө тусган шийдвэрлэх талаар байгууллагуудад албан тоот хүргүүлж хэрэгжилтийг эрчимжүүлэх

### **Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд**

Нийгмийн халамжийг хүртэгч хөдөлмөрийн насны зорилтот бүлгийн өрх, иргэний хэрэгцээ, чадавх боломжид тулгуурлан зан үйл, хандлагыг өөрчлөх, орлоготой, ажилтай болгох онцлог арга хэмжээг санаачлан хэрэгжүүлэх, энэ хүрээнд хэрэгжүүлсэн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах ажил зохион байгуулалтын дутагдлаас болж тасарч байгаа тул холбогдох нэгж, албан хаагчид анхаарч ажиллах

Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, орон нутгийн онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг эхний хагас жилд боловсруулан батлуулаагүй тасарсан байна. Иймд зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх

Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллан энэ хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар удирдлагууд, иргэдийг мэдээллээр хангах

Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт түншлэлийн гэрээг байгуулан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, тухайн жилд хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн Үндэсний хороонд хугацаанд хүргүүлэх

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт төлөвлөж, хэрэгжүүлэх

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг түрээсийн болон ипотекийн зээлд хамруулах талаар сургалт мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглэж зохион байгуулж зээлд хамрагдалтыг нэмэгдүүлэх

### **Байгаль орчин аялал жуулчлалын сайд:**

Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах

### **Батлан хамгаалахын сайд:**

Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзлыг хангасан иргэдийн төлбөр төлөлтөд хяналт тавьж мөнгөн төлбөрийг бүрэн төлүүлэх арга хэмжээ авч, сум багийн Засаг дарга нарын хариуцлагыг дээшлүүлэх

Батлан хамгаалах газрын даргын удирдлагын байрыг шинээр төхөөрөмжлөх, төсөв хөрөнгийг байгууллагын төсөвт тусган шийдвэрлэх

### **Эдийн засаг, хөгжлийн сайд:**

Улаанбаатар хотоос хөдөө, орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих ажлын хүрээнд шилжилт хөдөлгөөн хийсэн иргэд, аж ахуйн нэгжээс судалгаа авах ажлыг зохион байгуулах, судалгааны үр дүнг нэгтгэн гаргаж улирал бүр удирдлагуудыг мэдээллээр хангахаас гадна Эдийн засаг, хөгжлийн яаманд судалгааны үр дүнг хүргүүлэх

### **Тайлан мэдээ ирүүлэх талаар өгөх зөвлөмж**

1. Хэрэгжилт удаашралтай, тасарч болзошгүй байгаа болон хугацаа болоогүй заалтуудыг хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулан хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх арга хэмжээ авах /холбогдох хэлтэс, агентлагийн дарга нар/
2. Жилийн эцсийн тайланг ирүүлэхдээ гэрээний хүрээнд зарцуулсан хөрөнгийн хэмжээг эх үүсвэр тус бүрээр, мөн арга хэмжээ тус бүрийн хүрээнд хийсэн ажлыг нотлох баримттайгаар гаргаж ирүүлэх /хэлтэс, агентлагийн дарга нар/
3. Тайланг заасан хугацаанд ирүүлж байх мөн тайлангийн чанарт анхаарч агентлагийн дарга нар хянаж ирүүлж байх /агентлагийн дарга нар/

ТАЙЛАНГ ХЯНАСАН:  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА *Э. Энх* Д.ДААРИЙМАА

ТАЙЛАН БИЧСЭН:  
ХШҮХ-ИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *Э.Э* Э.ОДОНЧИМЭГ